



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 19/415

Есөнбулаг

Г Гэрээ шууд байгуулж, гүйцэтгүүлэх Г  
эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэх тухай" 124 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн 1,164,471 (нэг сая нэг зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун далан нэг) төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Ахмадын хорооны барилгын гадна фасадны засварын ажлыг шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Ахмадын хороо (С.Галсанчоймбол)-нд шилжүүлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн аймгийн Ахмадын хороо (С.Галсанчоймбол)-нд тус тус үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

